ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Тэлмэн сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/165/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
   2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга 8
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан 13
   4.1 Ерөнхий зүйл 13
   4.2 Материаллаг байдал 14
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт 14
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 14
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 15
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 16
5. Аудитын илрүүлэлт 16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.17 № 129

танай ______ -ны № ______ -т

ТЭЛМЭН СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ӨЛЗИЙСАЙХАН-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэлмэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэлмэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тэлмэн сумын цэцэрлэгт 46,128.9 мянган төгрөгийн хөрөнгө, 592.0 мянган төгрөгийн материал хандив тусламжаар ирснийг данс бүртгэлд тусгаж, 6,717.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Аудитын гол асуудал

Тэлмэн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тэлмэн сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 48 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 97.4 хувьтай хэрэгжжээ. Тус цэцэрлэг нь тайлант онд улсын болон орон нутгийн төсвөөс 818,035.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 41.0 мянган төгрөгийн бусад орлоготой, 804,290.5 мянган төгрөгийг зарцуулж, 91,341.5 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй ажиллажээ. Нийгмийн даатгалын газар, Татварын газарт, хувь хүнээс 62,627.6 мянган төгрөгийн авлагатай, 3 байгууллагуудад 556.6 мянган төгрөгийн өглөгтэй ажиллажээ. Авлага, өглөгийг тооцооны баримтаар баталгаажуулж, тайлан балансt тусгасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *төгрөгөөр*

| ДАНС | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 89,300,973.83 | 92,892,267.69 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 16,648,853.80 | 19,527,763.80 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 16,648,853.80 | 19,527,763.80 |
| 3121 | Төгрөг | 16,648,853.80 | 19,527,763.80 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 16,648,853.80 | 19,527,763.80 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 0.00 | - |
| 33 | АВЛАГА | 3,561,126.14 | - |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 3,561,126.14 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 69,090,993.89 | 73,364,503.89 |
| 351 | Түүхий эд материал | 181,500.00 | - |
| 35130 | Эм боох материал | 181,500.00 | - |
| 354 | Хангамжийн материал | 68,909,493.89 | 73,364,503.89 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 443,750.00 | 821,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 63,283,040.89 | 68,016,380.89 |
| 35460 | Хүнсний материал | 4,087,883.00 | 3,431,903.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,094,820.00 | 1,094,820.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 335,490,752.57 | 340,362,213.32 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 335,490,752.57 | 340,362,213.32 |
| 392 | Биет хөрөнгө | 330,280,877.57 | 335,324,213.32 |
| 39201 | Барилга, байгууламж | 354,067,637.00 | 354,067,637.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (63,226,363.80) | (75,871,636.56) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 52,770,193.00 | 67,501,553.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (26,752,339.07) | (34,347,198.88) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 37,400,409.80 | 51,080,409.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (25,647,959.88) | (28,469,184.84) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 8,362,757.50 | 8,362,757.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (7,161,646.98) | (7,468,313.70) |
| 39217 | Номын фонд | 468,190.00 | 468,190.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 5,209,875.00 | 5,038,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,650,000.00 | 1,650,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (1,478,125.00) | (1,650,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,038,000.00 | 5,038,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 424,791,726.40 | 433,254,481.01 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 0.00 | 2,037,316.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 2,037,316.00 |
| 413 | Өглөг | 0.00 | 2,037,316.00 |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 0.00 | 2,037,316.00 |
| 4136 | Бусад өглөг | 0.00 | 0.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 0.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 424,791,726.40 | 431,217,165.01 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 424,791,726.40 | 431,217,165.01 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 418,508,960.38 | 418,508,960.38 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 418,508,960.38 | 418,508,960.38 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (58,330,924.42) | (51,905,485.81) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (58,330,924.42) | (58,330,924.42) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 6,425,438.61 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 64,613,690.44 | 64,613,690.44 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 424,791,726.40 | 433,254,481.01 |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 604,451,626.84 | 864,796,924.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 31,951,926.84 | 46,761,924.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 31,951,926.84 | 46,761,924.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | |
| 120009 | Бусад орлого | 82,000.00 | 41,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 3,679,511.84 | 46,128,924.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 28,190,415.00 | 592,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 572,499,700.00 | 818,035,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 517,636,800.00 | 757,233,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 517,636,800.00 | 757,233,400.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 54,862,900.00 | 60,801,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 54,862,900.00 | 60,801,600.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 531,586,796.02 | 754,199,572.45 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 531,586,796.02 | 754,199,572.45 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 517,818,097.12 | 734,543,142.01 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 321,923,461.00 | 505,145,427.19 |
| 210101 | Үндсэн цалин | 234,467,197.00 | 349,584,204.19 |
| 210102 | Нэмэгдэл | 76,241,282.00 | 135,686,551.00 |
| 210104 | Урамшуулал | 11,214,982.00 | 19,874,672.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 40,190,316.01 | 62,634,126.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,482,122.35 | 39,421,426.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,381,294.20 | 5,803,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,951,316.29 | 2,901,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 607,858.76 | 2,901,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,767,724.41 | 11,606,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 48,815,201.10 | 52,659,169.56 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,901,151.10 | 6,884,234.56 |
| 210302 | Түлш, халаалт | 41,724,550.00 | 45,654,935.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 189,500.00 | 120,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 4,309,319.50 |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,057,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 992,419.50 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 2,259,700.00 |
| 2105 | Нормативт зардал | 65,446,350.00 | 67,011,050.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 381,000.00 | 469,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 65,065,350.00 | 66,541,750.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,298,440.00 | 5,862,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,298,440.00 | 5,862,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,700,100.00 | 1,976,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,700,100.00 | 1,976,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 977,500.00 | 2,259,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 977,500.00 | 2,259,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,466,729.01 | 32,685,449.12 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,594,660.00 | 5,835,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,572,500.00 | 6,757,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 21,299,569.01 | 20,093,249.12 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,768,698.90 | 19,656,430.44 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 9,530,600.00 | 13,514,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,530,600.00 | 13,514,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 4,238,098.90 | 6,142,430.44 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,238,098.90 | 6,142,430.44 |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 72,864,830.82 | 110,597,351.55 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 1,933,000.00 | |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 1,933,000.00 | |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -1,933,000.00 | |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 70,931,830.82 | 110,597,351.55 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 572,581,700.00 | 818,076,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 82,000.00 | 41,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 82,000.00 | 41,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | |
| 120009 | Бусад орлого | 82,000.00 | 41,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 572,499,700.00 | 818,035,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 517,636,800.00 | 757,233,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 517,636,800.00 | 757,233,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 54,862,900.00 | 60,801,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 54,862,900.00 | 60,801,600.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 512,394,442.26 | 804,290,465.50 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 512,394,442.26 | 804,290,465.50 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 498,625,743.36 | 784,634,035.06 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 320,772,198.00 | 553,958,646.00 |
| 210101 | Үндсэн цалин | 233,312,934.00 | 398,397,423.00 |
| 210102 | Нэмэгдэл | 76,241,282.00 | 135,686,551.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 11,217,982.00 | 19,874,672.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 45,250,344.26 | 72,539,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,387,144.26 | 49,327,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,965,600.00 | 5,803,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,172,800.00 | 2,901,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 792,800.00 | 2,901,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,932,000.00 | 11,606,300.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 48,624,801.10 | 52,659,169.56 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,901,151.10 | 6,884,234.56 |
| 210302 | Түлш, халаалт | 41,534,150.00 | 45,654,935.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 189,500.00 | 120,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 2,651,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 1,057,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 1,594,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 57,960,000.00 | 74,236,600.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 809,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 57,960,000.00 | 73,427,300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,000,000.00 | 5,862,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 5,862,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,700,100.00 | 1,976,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,700,100.00 | 1,976,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 977,500.00 | 2,259,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 977,500.00 | 2,259,800.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,340,800.00 | 18,489,619.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,408,300.00 | 11,732,619.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,932,500.00 | 6,757,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,768,698.90 | 19,656,430.44 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 9,530,600.00 | 13,514,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,530,600.00 | 13,514,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 4,238,098.90 | 6,142,430.44 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,238,098.90 | 6,142,430.44 |
| III | Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (3)=(1)-(2) | 60,187,257.74 | 13,785,534.50 |
| V | Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн (5) | | 4,440,264.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | | 4,440,264.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 4,440,264.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | | -4,440,264.00 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 60,187,257.74 | 9,345,270.50 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 81,996,214.34 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 91,341,484.84 |

*Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан*

мянган /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|
| 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 45,804,237.70 | 47,760,339.90 | 779,010,311.82 | 872,574,889.42 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | 110,597,351.55 | 110,597,351.55 |
| 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 45,804,237.70 | 47,760,339.90 | 889,607,663.37 | 983,172,240.97 |

*Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | 81,996,214.34 | -81,996,214.34 | |
| **71801 - сургуулийн өмнөх боловсрол** | | | | | |
| **80233 - хүүхэд хамгаалал** | | | | | |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 994,300.00 | 994,300.00 | | 100 |
| **2** | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 994,300.00 | 994,300.00 | | 100 |
| **21** | Урсгал зардал | 994,300.00 | 994,300.00 | | 100 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 994,300.00 | 994,300.00 | | 100 |
| **81605 - ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ** | | | | | |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,559,300.00 | 1,559,300.00 | | 100 |
| **2** | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 1,559,300.00 | 1,559,300.00 | | 100 |
| **21** | Урсгал зардал | 1,559,300.00 | 1,559,300.00 | | 100 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,559,300.00 | 1,559,300.00 | | 100 |
| **81807 - цэцэрлэгийн хүүхдийн хоол** | | | | | |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 75,207,400.00 | 73,436,400.00 | 1,771,000.00 | 97.65 |
| **2** | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 75,207,400.00 | 73,427,300.00 | 1,780,100.00 | 97.63 |
| **21** | Урсгал зардал | 75,207,400.00 | 73,427,300.00 | 1,780,100.00 | 97.63 |
| **2105** | Нормативт зардал | 75,207,400.00 | 73,427,300.00 | 1,780,100.00 | 97.63 |
| 210502 | Хоол, хүнс | 75,207,400.00 | 73,427,300.00 | 1,780,100.00 | 97.63 |
| **81816 - зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр** | | | | | |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 2,371,400.00 | 2,371,400.00 | | 100 |
| **2** | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 2,371,400.00 | 2,191,964.00 | 179,436.00 | 92.43 |
| **21** | Урсгал зардал | 2,371,400.00 | 2,191,964.00 | 179,436.00 | 92.43 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,371,400.00 | 2,191,964.00 | 179,436.00 | 92.43 |
| **81823 - боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх** | | | | | |
| **2** | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 1,559,300.00 | 1,559,300.00 | | 100 |
| **21** | Урсгал зардал | 1,559,300.00 | 1,559,300.00 | | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,559,300.00 | 1,559,300.00 | | 100 |
| **81833 - явуулын багшийн үйлчилгээ** | | | | | |
| **2** | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 16,929,100.00 | 16,785,322.00 | 143,778.00 | 99.15 |
| **21** | Урсгал зардал | 16,929,100.00 | 16,785,322.00 | 143,778.00 | 99.15 |
| **210** | Бараа, ажил үйлчилгээний зардал | 16,929,100.00 | 16,785,322.00 | 143,778.00 | 99.15 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 11,286,100.00 | 11,142,322.00 | 143,778.00 | 98.73 |
| 21 | Үндсэн цалин | 9,480,300.00 | 7,323,264.00 | 2,157,036.00 | 77.25 |
| 210 | Нэмэгдэл | 1,805,800.00 | 3,819,058.00 | -2,013,258.00 | 211.49 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,410,700.00 | 1,410,700.00 | | 100 |
| 210 | Тэтгэврийн даатгал | 959,300.00 | 959,300.00 | | 100 |
| 210 | Тэтгэмжийн даатгал | 112,900.00 | 112,900.00 | | 100 |
| 210 | ҮОМШӨ-ний даатгал | 56,400.00 | 56,400.00 | | 100 |
| 21 | Ажилгүйдлийн даатгал | 56,400.00 | 56,400.00 | | 100 |
| 210 | Эрүүл мэндийн даатгал | 225,700.00 | 225,700.00 | | 100 |
| 210 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,232,300.00 | 4,232,300.00 | | 100 |
| **81834 - боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх** | | | | | |
| 122 | Төсвөөс санхүүжих | 707,722,700.00 | 627,497,500.00 | 80,225,200.00 | 88.66 |
| **2** | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 707,722,700.00 | 626,700,643.50 | 81,022,056.50 | 88.55 |
| **21** | Урсгал зардал | 707,722,700.00 | 626,700,643.50 | 81,022,056.50 | 88.55 |
| **210** | Бараа, ажил үйлчилгээний зардал | 707,722,700.00 | 626,700,643.50 | 81,022,056.50 | 88.55 |
| **2101** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 616,831,700.00 | 539,631,824.00 | 77,199,876.00 | 87.48 |
| 210 | Үндсэн цалин | 434,450,900.00 | 391,074,159.00 | 43,376,741.00 | 90.02 |
| 210 | Нэмэгдэл | 176,800,500.00 | 131,867,493.00 | 44,933,007.00 | 74.59 |
| 210 | Урамшуулал | 5,580,300.00 | 16,690,172.00 | -11,109,872.00 | 299.09 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 72,138,400.00 | 70,393,300.00 | 1,745,100.00 | 97.58 |
| 210 | Тэтгэврийн даатгал | 49,055,400.00 | 47,867,500.00 | 1,187,900.00 | 97.58 |
| 210 | Тэтгэмжийн даатгал | 5,769,800.00 | 5,631,500.00 | 138,300.00 | 97.6 |
| 210 | ҮОМШӨ-ний даатгал | 2,885,500.00 | 2,815,700.00 | 69,800.00 | 97.58 |
| 210 | Ажилгүйдлийн даатгал | 2,885,500.00 | 2,815,700.00 | 69,800.00 | 97.58 |
| 210 | Эрүүл мэндийн даатгал | 11,542,200.00 | 11,262,900.00 | 279,300.00 | 97.58 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,259,800.00 | 2,259,800.00 | | 100 |
| 210 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,259,800.00 | 2,259,800.00 | | 100 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,492,800.00 | 14,415,719.50 | 2,077,080.50 | 87.41 |
| 210 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,735,800.00 | 7,658,719.50 | 2,077,080.50 | 78.67 |
| 210 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,757,000.00 | 6,757,000.00 | | 100 |
| **81835 - сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 32,886,100.00 | 24,711,000.00 | 8,175,100.00 | 75.14 |
| 21 | Урсгал зардал | 32,886,100.00 | 24,711,000.00 | 8,175,100.00 | 75.14 |
| 210 | Бараа, ажил үйлчилгээний зардал | 19,372,100.00 | 11,197,000.00 | 8,175,100.00 | 57.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 10,751,300.00 | 3,184,500.00 | 7,566,800.00 | 29.62 |
| 210 | Урамшуулал | 10,751,300.00 | 3,184,500.00 | 7,566,800.00 | 29.62 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,344,000.00 | 735,700.00 | 608,300.00 | 54.74 |
| 210 | Тэтгэврийн даатгал | 913,900.00 | 500,200.00 | 413,700.00 | 54.73 |
| 210 | Тэтгэмжийн даатгал | 107,500.00 | 58,800.00 | 48,700.00 | 54.7 |
| 210 | ҮОМШӨ-ний даатгал | 53,800.00 | 29,500.00 | 24,300.00 | 54.83 |
| 210 | Ажилгүйдлийн даатгал | 53,800.00 | 29,500.00 | 24,300.00 | 54.83 |
| 210 | Эрүүл мэндийн даатгал | 215,000.00 | 117,700.00 | 97,300.00 | 54.74 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,276,800.00 | 7,276,800.00 | | 100 |
| 210 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,276,800.00 | 7,276,800.00 | | 100 |
| 213 | Урсгал шилжүүлэг | 13,514,000.00 | 13,514,000.00 | | 100 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 13,514,000.00 | 13,514,000.00 | | 100 |
| 213 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,514,000.00 | 13,514,000.00 | | 100 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | 81,996,214.34 | -81,996,214.34 | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | 91,341,484.84 | -91,341,484.84 | |

*Аудит хийсэн нэмэлт санхүүжилтын тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | | |
| **71801 - сургуулийн өмнөх боловсрол** | | | | | |
| **80109 - тзш-ийн байгууллагуудын тогтмол зардал** | | | | | |
| **12** | Татварын бус орлого | 403,334,100.00 | 60,801,600.00 | 342,532,500.00 | 15.07 |
| **1220** | Тусламжийн орлого | 403,334,100.00 | 60,801,600.00 | 342,532,500.00 | 15.07 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 403,334,100.00 | 60,801,600.00 | 342,532,500.00 | 15.07 |
| **2** | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 403,334,100.00 | 60,801,600.00 | 342,532,500.00 | 15.07 |
| **21** | УРСГАЛ ЗАРДАЛ | 403,334,100.00 | 54,659,169.56 | 348,674,930.44 | 13.55 |
| **210** | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 403,334,100.00 | 54,659,169.56 | 348,674,930.44 | 13.55 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 399,334,100.00 | 52,659,169.56 | 346,674,930.44 | 13.19 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,042,900.00 | 13,157,644.56 | 885,255.44 | 93.7 |
| 210302 | Түлш, халаалт | 384,337,800.00 | 39,381,525.00 | 344,956,275.00 | 10.25 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 21030 3 | Цэвэр, бохир ус | 953,400.00 | 120,000.00 | 833,400.00 | 12.59 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,000,000.00 | 2,000,000.00 | 2,000,000.00 | 50 |
| 21060 4 | Урсгал засвар | 4,000,000.00 | 2,000,000.00 | 2,000,000.00 | 50 |
| 26109 0 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 6,142,430.44 | -6,142,430.44 | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Завхан аймгийн Тэлмэн сумын хүүхдийн цэцэрлэгийн чиглэл:***

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

***Завхан аймгийн Тэлмэн сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго:*** Завхан аймгийн Тэлмэн сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, 2-5 насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах, 5 настай хүүхдийг 200-аас доошгүй цагийн сургалтад 100 хувь хамруулах зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 48 арга хэмжээ төлөвлөснөөс 97,4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Завхан аймгийн Тэлмэн сумын хүүхдийн цэцэрлэгийн*** *үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд "төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай", "орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай", "цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх" зэрэг Засгийн газрын тогоолуудад өөрчлөлт орсон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус цэцэрлэг нь

дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн *Тэлмэн сумын хүүхдийн цэцэрлэгийн* 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Тэлмэн сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 108,223.3 мянган төгрөгөөр буюу 12.36 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 81.996.2 | 91,341.5 | 9,345.0 |
| Авлага | 5,060.0 | 62,627.6 | 57,568.0 |
| Бараа материал | 88,078.1 | 98,912.6 | 10,834.5 |
| Үндсэн хөрөнгө | 700,371.2 | 730,847.1 | 30,475.9 |
| **Нийт хөрөнгө** | **875,505.5** | **983,728.8** | **108,223.3** |
| Өр төлбөрийн дүн | 2,930.6 | 556.5 | 2,374.1 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 872,574.9 | 983,172.2 | 110,597.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **875,505.5** | **983,728.8** | **108,223.3** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайлант онд:**

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 9,345.0 мянган төгрөгөөр, авлага 57,558.0 мянган төгрөгөөр өсчээ. Нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг холбогдох байгууллагын дансанд илүү шилжүүлснээр авлага их хэмжээгээр өссөн байна. Авлагыг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулжээ.

Тус цэцэрлэг нь оны эхэнд 88,078.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр болон хандив тусламж, өөрийн орлогоор 97,282.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогот авч 86,448.1 мянган төгрөгийн зарцуулалт хийснээр оны эцэст 98,912.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Үндсэн хөрөнгийн хувьд 50,569.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг төсвийн болон өөрийн хөрөнгө, хандив тусламжаар авч бүртгэлд тусгажээ. 6,717.0 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох газрын шийдвэрээр бүртгэлээс хасч 879,250.8 мянган төгрөгийн хөрөнгийг тоолж, тооцооны баримт үйлдэн баталгаажуулжээ. Мөн тайлант онд элэгдлийн зардалд 20,093.2 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Ажиллагсадтай холбоотой өмнөх оны өглөгийг 100 хувь барагдуулж, байгууллагад төлөх өглөгийн хэмжээг 2,374.1 мянган төгрөгөөр буюу 57.7 хувиар бууруулж ажиллажээ. Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 983,172.2 мянган төгрөгт тайлант онд өөрчлөлт ороогүй болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 840,937.0 мянган төгрөг, нийт зарлагыг 840,937.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тодотголоор нэмж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 747,929.0 мянган төгрөг буюу 89.0 хувьтай байгаа нь хүүхэд хамгаалал, эрүүл мэнд, багш нарын мэргэжил дээшлүүлэх зардлуудыг 100 хувь зарцуулж, бусад зардлуудыг 9.1 мянган төгрөгөөс 81,022.1 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| **71801** | Сургуулийн өмнөх боловсрол | 840,937.0 | 747,929.0 | 93,008.0 | 89.0 |
| 80233 | Хүүхэд хамгааллын зардал | 994.3 | 994.3 | - | 100 |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих зардал | 1,559.3 | 1,559.3 | - | 100 |
| 81807 | Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал | 73,436.4 | 73,427.3 | 9.1 | 99.99 |
| 81816 | Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр | 2,371.4 | 2,191.9 | 179.4 | 92.43 |
| 81823 | Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардал | 1,559.3 | 1,559.3 | - | 100 |
| 81833 | Явуулын багшийн үйлчилгээ | 16,929.1 | 16,785.3 | 143.8 | 99.15 |
| 81834 | Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал | 707,722.7 | 626,700.6 | 81,022.1 | 88.55 |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал | 38,361.5 | 24,711.0 | 13,650.5 | 64.42 |
| **НИЙТ** | | **840,937.0** | **747,929.0** | **93,008.0** | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 60,801.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашишлалттай холбоотой зардалд 52,659.2 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2,000.0 төгрөгийг тус тус зарцуулж, 6,142.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

**Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

**3.5.4**

**3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар**

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Мөнх-өвгөдий ХХК-тай шууд худалдан авах гэрээ | Хүнсний болон аж ахуйн материал | 73,427.3 | 73,418.2 |
| 2 | Энх-өвгөдий ХХК-тай шууд худалдан авах гэрээ | Хүнсний болон аж ахуйн материал | 6,757.0 | 6,757.0 |
| **ДҮН** | | | | |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Завхан аймгийн Тэлмэн сумын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Тэлмэн сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугээр сарын 03-ны өдрийн 15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс 1.5 хувиар тооцож, 7 685,9 мянган

төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувь буюу 5,764,4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завхан аймгийн Тэлмэн сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1. Цахим хэрэглээний дата багцыг бүх ажилчдад хавтгайруулан олгохгүй байх

2. Гэрэл цахилгааны үнийг төлөхдөө нэхэмжлэлд бичигдсэн зөвхөн 1 гэсэн квт-ыг үндэслэн шилжүүлэг хийж байна. АУЭХС төрийн өмчит хувьцаат компаниас үндсэн нэхэмжлэлийг авч, хянаж, мөнгийг шилжүүлж хэвших

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

**5.1 Төлбөрийн акт: тогтоогоогүй**

**5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

**5.3 Зөвлөмж: өгөгдөөгүй**

Аудитын явцад материаллаг шинж чанартай алдаа илрээгүй тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-20

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМБО АУДИТ" ХХК-НИЙ АУДИТОР Р.МЯДАГМАА

Огноо: 2025-02-20